



**АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2018 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/181

Улаанбаатар хот

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дах заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ийн 1.2, 2.1 дэх заалт, мөн Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын дүрмийн 6.12 дах заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 8.6 зүйл заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Тус үндэсний төвийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга
Хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:
Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтсийн хууль эрх зүйн тасгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хариуцсан мэргэжилтэн


Гишүүд:
Санхүү эдийн засгийн хэлтсийн хяналтын нягтлан бодогч
Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтсийн дотоод ажил, аж ахуй үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
Мэдээллийн технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Хөдөлгөөний удирдлагын хэлтсийн хөдөлгөөний хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн
Техникийн хяналтын хэлтсийн тоног төхөөрөмжийн засварын ахлах инженер
Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсийн өмчлөлийн бүртгэлийн тасгийн ахлах мэргэжилтэн
Хууль, эрх зүйн тасгийн хуулийн мэргэжилтэн

2. Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмыг баримтлан

ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөл / Хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга /-д даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан үйлдвэрийн газрын захирлын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/228 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ



Б.ГҮРСОРОНЗОН